



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

**Хүний папиллома вирусийн эсрэг
дархлаажуулалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлах тухай” 472 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1256 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг дүүрэгт зохион байгуулсугай.

2.Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т даалгасугай.


4.Дархлаажуулалтыг чанар үр дүнтэй зохион байгуулахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д, дархлаажуулалтад 11 настай хүүхдүүдийг бүрэн хамруулахыг 1 дүгээр хороо (Н.Нямзав), 2 дугаар хороо (Б.Батзориг), “Хангай” сургууль (Э.Соёмбобат) нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны... дугаар сарын... ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ЭСРЭГ
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ш.Баасансүрэн	Боловсролын хэлтсийн дарга
	Э.Соёмбобат	"Хангай" сургуулийн захирал
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичиг:	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга